



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



## АМЬДАРЧ БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 2020



Сайншанд 2021 он

## АГУУЛГА

Оршил .....	2
Орон сууцны нөхцөл.....	4
Ахуйн нөхцөл.....	6
Нийгмийн үзүүлэлтүүд.....	12
Хөдөлмөр эрхлэлт .....	14
Дүгнэлт .....	18

## ОРШИЛ

Монгол улсын хүн амын амьдралын орчин хэв маягт ихээхэн өөрчлөлт орж богино хугацаанд хувьсан өөрчлөгдөж байгаа билээ.

Аливаа улс орны эдийн засгийн хөгжил, иргэдийнх нь аж байдал, амьдрах орчин нөхцөлтэй салшгүй холбоотой байдаг.

БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид, Засгийн газраас орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтыг шинэчлэх шийдвэр ёсоор Дорноговь аймаг, ардын төлөөлөгчдийн анхдугаар их хурлын хуралдаанаар 1931 онд байгуулагдсан юм. Үүнээс өмнө Түшээтхан аймгийн Говь мэргэн Вангийн хошуу хэмээн нэрлэгдэж байв.

Дорноговь аймаг 109.4 мян.га.км нутаг дэвсгэртэй Өмнөговь, Дундговь, Говь-Сүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хаяа нийлэн айлсаж, өмнө талаараа 600 гаруй км газраар БНХАУ-тай хиллэдэг. Аймгийн төв нь Сайншанд хот бөгөөд Улаанбаатар хотоос 456 км.

Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 54,8 хувь нь оршин сууж байна. Хилийн байнгын үйл ажиллагаатай "Замын-Үүд", "Ханги" боомтуудтай. Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдсэнээр Монгол улсын хөгжил дэвшлийн нэгэн үүд хаалга болон хөгжиж байна.

Аймгийн нутаг дэвсгэр нь Европын Белги, Дани, Люксембург, Швейцари улсуудын дэвсгэр нутгийг нийлүүлсэнтэй тэнцэнэ.

Нийт 71.2 мянган хүн амтай, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 14 сум, 65 багтай. Тус аймгийн Даланжаргалан, Айраг, Сайншанд, Өргөн, Эрдэнэ, Замын үүд сумдын нутгаар нийт 500 гаруй км төмөр зам дайран өнгөрдөг.

Манай аймаг нь ашигт малтмалаар баялаг бөгөөд одоогийн байдлаар хайлуур жонш, цеолет, гөлтгөнө, чулуун нүүрс, газрын тос, алт, зэс, никель, төмөр, марганец, хром, гянт болд, цагаан тугалганы зэрэг 38 төрлийн ашигт малтмалын 73 орд, 440 гаруй илэрцүүд тогтоогдсон байна. Мөн тус аймагт Монгол орны хэмжээнд тогтоогдсон хайлуур жоншны нийт нөөцийн 30.0 хувь бий.

Байгалийн баялаг, ашигт малтмал, эрдсийн энэхүү ихээхэн нөөц нь уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжих тааламжтай нөхцөл болж байна. Тус аймгийн нутагт орон нутгийн төдийгүй, улс орны эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий Зүүнбаян, Цагаан элсний газрын тос агуулсан хотгор байрладаг. Даланжаргалан сумын Хөх цав болон Өргөн сумын Сэнжит худгийн ордуудыг түшиглэн жилд 1 сая тн-н хүчин чадалтай цементүүдийн үйлдвэрүүд ашиглалтад ороод байна.

Дорноговь аймаг физик газарзүйн шинжээрээ говийн их мужид үндсэндээ багтдаг.Эх газрын эрс тэс уур амьсгалтай жилийн 260-280 өдөр нь нартай цэлмэг, хур дунадас бага байдаг. Зуны улиралд +40 +41 хэм халдаг ба салхины дундаж хурд 4.2-4.6

м/сек, заримдаа 35 м/сек хүрдэг. Ургамалын хувьд 46-н овог 181 төрөл 327 зүйл ургамал байдгаас 30 гаруй төрлийн эмийн ургамал ургадаг.

Амьтны аймгаар нэн ааялаг бөгөөд үслэг амьтадаас чоно, үнэг, хярс, туулай, өмхий хүрэн, дорго, мануул, тарвага, туурайтнаас цагаан зээр, хар сүүлт байдаг. Дэлхийд ховордож "Улаан номонд бичигдсэн аргаль, янгир, шилүүс, хулан сүрэг сүргээрээ байдаг онцлогтой.

Дорноговь аймаг зэс молибден, жонш, нефть, нүүрс, шатах занар, төмрийн хүдэр, алт, мөнгө, газрын ховор элемент, гөлтгөнө, оюу, номин усан ба утаат болор, мана, гартаам, гантиг зэрэг байгалийн арвин их үнэт баялагтай бөгөөд 30 орчим төрлийн 200 гаруй орд илэрцүүд тогтоогдож зарим ордуудаас олборлолт баяжуулалт хийдэг.

Тус аймгийн Эргэлийн зоо, Баянгийн ширээ, Хоёр зааны хөндий, Хамарын хурал зэрэг газраас 80 гаруй сая жилийн тэртээ амьдарч байсан үлэг гүрвэлийн чулуужсан яс, далай тэнгисийн амьтан ургамалын үлдэгдэл, чулуужсан мод зэрэг палеонтологийн чухал олдворууд, 30-аад сая жилийн өмнөх үеийн намгийн хирсны толгой, одос үхэр, тэмээн хяруулын өндөг зэрэг туурайтан, махчин, хөхтөн амьтадын яс зэргийг гадаадын болон дотоодын эрдэмтэд судлаачид илрүүлэн гаргасан байдаг.


Мөн говь нутаг хүн төрөлхтөний өлгий нутаг болохыг илэрхийлэх эртний хүмүүсийн үлдээсэн чулуун зэвсгийн дурсгалууд, хадны сүг зураг, хүрлийн болон төмрийн үеийн зэвсэг хэрэглэлүүд, булш бунхан, гэрэлт хөшөө, хот балгадын буйр, туурь зэрэг түүх соёлын үл хөдлөх дурсгалуудаар нэн баялаг юм.

Тус аймгаас улсын баатар 1, Ардын багш 1, хөдөлмөрийн баатар 8, төрийн соёрхолт 4, гавъяат 34, улсын аварга малчин 45, эрдэмтэн 37 төрөн гарчээ.Тус аймагт гадаад дотоодын аялагчид, жуулчдын сонирхдог гол зүйл нь дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн ноён хутагт Данзанравжаагийн музей, түүний үүсгэн байгуулсан Хамарын хийд, Шамбалын орон орчмын шашин, түүний дурсгалт газрууд байдаг.

Аймгийн бүх сумд эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн хамрагдаж, нийслэлээс 450 км алслагдсан аймгийн төв Сайншанд хот төмөр, зам болон хатуу хучилттай засмал замаар Улаанбаатар хот, Замын-Үүд сумтай холбогдсон байна. Мөн холбоо, мэдээллийн технологи харьцангуй хөгжиж бүх сумд 100.0 хувь шилэн кабель, болон сансрын холбооны систем тоон сүлжээг ашиглаж байна.

## 1. ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 2020 оны байдлаар нийт өрх 20 494 болж өмнөх 2010 оноос 3951 өрх буюу 23.9 хувиар өссөн байна. Нийт өрхийн 8976(43.8%) нь гэрт, 11424 (55.7%) нь байшинд, 94 (0.5%) нь бусад сууцанд амьдарч байна. Өмнөх 2010 онтой харьцуулахад байшинд амьдардаг өрх 1.1 пунктээр нэмэгдэв. Энэ нь сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд нэмэгдсэнээр орон сууцанд амьдардаг өрхийн тоо нэмэгдсэн байна. Энэ нь хүний амьдралын анхдагч хэрэгцээ, эрүүл энх, тав тухтай, аюулгүй амьдрах үндсэн орчин бол орон сууц юм.



## Хүснэгт 1: СУУЦНЫ ТӨРӨЛ, сумаар 2010, 2020 он

Сум	Сууцны төрлөөр				
	2010	2020	Гэр	Байшин	Бусад сууц
<b>Бүгд</b>	<b>16543</b>	<b>20494</b>	<b>8976</b>	<b>11424</b>	<b>94</b>
Айраг	1173	1120	638	480	2
Алтанширээ	340	479	392	81	6
Даланжаргалан	767	943	555	384	4
Дэлгэрэх	453	568	475	88	5
Замын-Үүд	3759	4828	1492	3323	13
Иххэт	625	672	434	235	3
Мандах	412	500	368	128	4
Өргөн	514	709	363	345	1
Сайншанд	5780	7432	2056	5342	34
Сайхандулаан	310	467	377	84	6
Улаанбадрах	425	520	399	118	3
Хатанбулаг	891	1018	708	309	1
Хөвсгөл	414	486	341	143	2
Эрдэнэ	680	752	378	364	10

Монголын ард түмний уламжлалт сууц гэрт амьдардаг өрх нийт өрхийн 43.8 хувь байгаа нь 2010 оноос 1.6 пунктээр буурч, харин байшинд амьдардаг өрх 1.1 пунктээр өссөн байна.

Хот хөдөөд өрхийн сууцны төрөл харилцан адилгүй байдаг. Тухайлбал байшинд амьдардаг өрхийн 8665 (75.8%) нь хотод, 2759( 24.2%) нь хөдөөд амьдардаг өрх байна.

## 2.АХУЙН НӨХЦӨЛ

### ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, жижиг оврын цахилгаан үүсгүүр өргөн ашиглах болсон.

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн хангамж, хүрэлцээг тодорхойлж, цаашид холбогдох бодлого, хөтөлбөр, боловсруулах суурь, мэдээлэл бүрдүүлснээрээ ач холбогдолтой юм.

Нийт өрхийн 78.2 хувь нь төвлөрсөн системд холбогдсон өрх, 20.3 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй өрх, 0.9 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүртэй өрх, 0.2 хувь дизель станцтай өрх, харин нийт өрхийн 0.4 хувь нь цахилгааны ямар нэг эх үүсвэргүй байна.

Төвлөрсөн системд холбогдсон өрхийн тоо 2020 онд 16034 болж 2010 оноос 3612 өрхөөр нэмэгдсэн байна.

## Хүснэгт 2. ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, сумдаар 2020 он

Сум	Бүгд	Үүнээс				
		Төвлөрсөн систем	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оврын цахилгаан үүсгүүр	Цахилгааны эх үүсвэргүй
<b>Бүгд</b>	<b>20 494</b>	<b>16 034</b>	<b>32</b>	<b>4 154</b>	<b>190</b>	<b>84</b>
Айраг	1 120	779		331	9	1
Алтанширээ	479	146		320	7	6
Даланжаргалан	943	577		337	15	14
Дэлгэрэх	568	227	2	334	2	3
Замын-Үүд	4 828	4 785	3	9	25	6
Иххэт	672	386		282	2	2
Мандах	500	156		332	4	8
Өргөн	709	440		262	5	2
Сайншанд	7 434	7 284	2	110	27	11
Сайхандулаан	467	131		317	8	11
Улаанбадрах	520	174		340	5	1
Хатанбулаг	1 018	379	19	605	12	3
Хөвсгөл	484	146		277	52	9
Эрдэнэ	752	424	6	298	17	7

Цахилгааны эх үүсвэрийн төвлөрсөн системд холбогдсон нийт өрхийн 75.3 хувийг хотын өрх, 24.7 хувийг хөдөөгийн өрх эзэлж байна. Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоог өмнөх 2010 онтой харьцуулахад 397 өрх нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд цахилгааны эх үүсвэргүй 84 өрхийн 79.8 хувь нь хөдөөгийн өрх байна.

Хүснэгт 3. ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, хот, хөдөө 2010, 2020 он

	Цахилгааны эх үүсвэр						
	2010	2020	Төвлөрсөн систем	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оврын цахилгаан үүсгүүр	Цахилгааны эх үүсвэргүй
<b>Бүгд</b>	<b>16318</b>	<b>20 494</b>	<b>16 034</b>	<b>32</b>	<b>4154</b>	<b>190</b>	<b>84</b>
Хот	9391	12 262	12 069	5	119	52	17
Хөдөө	6927	8 232	3965	27	4 035	138	67

### ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР

Өрхийг халаалтын эх үүсвэрээр авч үзвэл нийт өрхийн 13 264 (64.7%) нь ердийн галлагаатай өрх, 6 573 (32.1%) хувь нь төвлөрсөн системд холбогдсон өрх, 517 (2.5 %) нь нам даралтын зуухтай өрх, 140 (0.7%) нь цахилгаан халаагуурын эх үүсвэртэй өрхүүд байна.

Халаалтын эх үүсвэр нь ердийн галлагаатай өрхийн тоо 2020 онд 13264 (64.7%) хувь болж 2010 оноос 1582 өрхөөр, төвлөрсөн системд холбогдсон сууцанд суудаг өрхийн тоо 2622 өрхөөр тус тус нэмэгдсэн байна.



## Хүснэгт 4: ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭРЭЭР, сумдаар

Сум	Үүнээс				
	2020	Ердийн галлагаа	Төвлөрсөн систем	Цахилгаан халаагуур	Нам даралтын зуух
Бүгд	20 494	13 264	6 573	140	517
Айраг	1 120	787	296	5	32
Алтанширээ	479	479			
Даланжаргалан	944	823	88	1	31
Дэлгэрэх	566	556		6	6
Замын-Үүд	4 829	2 646	1 796	85	301
Иххэт	673	481	187	1	3
Мандах	500	499			1
Өргөн	709	464	238	2	5
Сайншанд	7 432	3 519	3 803	35	77
Сайхандулаан	467	448	12	3	4
Улаанбадрах	520	512	4		4
Хатанбулаг	1 018	879	93	1	45
Хөвсгөл	486	482		1	1
Эрдэнэ	753	689	56		7

Зураг 1 ӨРХИЙН ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР 2020 он



## ӨРХИЙН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.

Аймгийн хэмжээнд зөөврийн усан хангамжтай өрхийн тоо 13922 буюу 67.9 хувийг эзэлж байна. Энэ нь гэрт амьдардаг өрхийн олонх нь хөдөө амьдардагтай холбоотой.

Нийт өрхийн 6572 буюу 32.1 хувь нь төвлөрсөн усан хангамжтай өрх байгаа нь 2010 оноос 9.4 пунктээр нэмэгдсэн байна.

## Хүснэгт 5. ӨРХИЙН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР,сумаар

Сум	Бүгд 2020	Үүнээс				
		Бие даасан систем - халуун, хүйтэн устай	Бие даасан систем - хүйтэн устай	Зөөврийн	Төвлөрсөн усан хангамж - халуун, хүйтэн устай	Төвлөрсөн усан хангамж - хүйтэн устай
Бүгд	20 494	59	53	13 922	2 848	3 612
Айраг	1 120	1		851	99	169
Алтанширээ	479			479		
Даланжаргалан	943	8		878	18	39
Дэлгэрэх	568		2	566		
Замын-Үүд	4 828	28	36	2 978	1 564	222
Иххэт	672	1		482	33	156
Мандах	500			500		
Өргөн	709		4	475	12	218
Сайншанд	7 434	17	10	3 624	994	2 789
Сайхандулаан	467	1		455		11
Улаанбадрах	520			518	2	
Хатанбулаг	1 018	1		925	89	3
Хөвсгөл	484			484		
Эрдэнэ	752	2	1	707	37	5

## БОХИР УС ЗАЙЛУУЛАТ

Аймгийн өрхийн бохир ус зайлуултыг авч үзвэл нийт өрхийн 7844 (38.3%) нь цооногт, 6272 (30.6%) нь ил задгай, 6252 (30.5%) нь төвлөрсөн системд холбогдсон, 126 (0.6%) нь бие даасан системтэй өрхүүд байна.

Аймгийн төвийн Сайншанд, Замын үүд сумын хувьд хамгийн их хүн амтай, орон сууцны барилга ихтэй учир төвлөрсөн системд холбогдон бохир усаа зайлуулдаг нийт өрхийн 85.8 хувийг эзэлж байна.

## Хүснэгт 6. ӨРХИЙН БОХИР,УС ЗАЙЛУУЛАЛТ,сумаар

Сум	Бүгд			Үүнээс	
	2020	Бие даасан систем	Задгай	Төвлөрсөн систем	Цооног
Бүгд	20 496	126	6 278	6 250	7 842
Айраг	1 120	3	606	265	246
Алтанширээ	479		443		36
Даланжаргалан	944	4	596	61	283
Дэлгэрэх	566	1	322		243
Замын-Үүд	4 829	48	614	1 797	2 370
Иххэт	673	1	298	188	186
Мандах	500		325		175
Өргөн	709	5	295	229	180
Сайншанд	7 432	58	585	3 567	3 222
Сайхандулаан	467		331	12	124
Улаанбадрах	520	1	340	3	176
Хатанбулаг	1 018	4	563	86	365
Хөвсгөл	486		466		20
Эрдэнэ	753	1	494	42	216

## ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ

Өрхийн хатуу хог хаягдлыг нэгдсэн бодлогоор ангилан ялгаж, тогтсон газар зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам сүлжээгээр зайлуулж, цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдолд ихээхэн нөлөөтэй.

Аймгийн нийт өрхийн 11256(54.9%) нь үйлчилгээний байгууллагаар, 3543(17.3%) нь тогтсон цэг байхгүй, 4778(23.3%) нь зөвшөөрөгдсөн цэгт, 917(4.5%) нь бусад/шатаадаг, булдаг/ газарт хог хаягдлыг зайлуулдаг өрхүүд байна.


Хатуу хог хаягдалаа үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлдэг өрхийн тоо 2020 онд 11256 буюу 54.9 хувь нь орон сууцанд амьдардаг өрх, мөн сум бүрт хог тээврийн машин ажилладаг болсон нь голлон нөлөөлж байна.

Хатуу хог хаягдалаа үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлдэг өрхийн тоог өмнөх 2010 онтой харьцуулахад 4183 өрх буюу 37.2 хувиар нэмэгдсэн байна.

## Хүснэгт 7. ӨРХИЙН ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ, сумаар

Сум	Бүгд		Үүнээс		
	2020	Зөвшөөрөгдсөн цэгт	Тогтсон цэг байхгүй	Үйлчилгээний байгууллагаар	Бусад
Бүгд	20 494	4 778	3 543	11 256	917
Айраг	1 120	436	298	323	63
Алтанширээ	479	68	307	77	27
Даланжаргалан	943	206	324	390	23
Дэлгэрэх	568	244	314	5	5
Замын-Үүд	4 828	758	51	4 018	1
Иххэт	672	8	267	378	19
Мандах	500	97	104	84	215
Өргөн	709	11	180	426	92
Сайншанд	7 434	2 137	194	5 059	44
Сайхандулаан	467	126	316	19	6
Улаанбадрах	520	18	165	158	179
Хатанбулаг	1 018	391	369	27	231
Хөвсгөл	484	139	345		
Эрдэнэ	752	139	309	292	12

Зураг.2. ӨРХИЙН ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ




3. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ЭРҮҮЛ МЭНД

2020 онд 398.4 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар, 16.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар тус тус буурч, 13.5 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оноос 1.5 хувиар өсчээ.

Зураг.3. Урьдчилан сэргийлэх тарилга мян.хүн




Зураг. 4. Амбулаторийн үзлэг, мян.хүн



## БОЛОВСРОЛ

Бүх шатны сургуульд суралцагчид 2020/2021 оны хичээлийн жилд 16.4 мянгад хүрч, өмнөх оноос 1.2(7.6%) мянгаар нэмэгдсэн байна.

Зураг.5. Бүх шатны сургуульд суралцагчид



Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 2020/2021 оны хичээлийн жилд 1675 хүүхэд элсэн орсон нь өмнөх оноос 20(1.2%)-өөр нэмэгджээ. Дотуур байранд нийт 749 хүүхэд амьдарч байгаагаас 382(51.0%) нь эмэгтэй, 554(74.0%) нь малчдын хүүхэд байна.

2020/2021 оны хичээлийн жилд их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд 1729 оюутан суралцаж байгаа нь өмнөх оноос 499(40.6%)-өөр өсчээ.


Аймгийн хэмжээнд 2020/2021 оны хичээлийн жилд 36 цэцэрлэгт, 5032 хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх оноос хүүхдийн тоо 8.8 хувиар буурч, цэцэрлэгийн тоо өмнөх оны мөн үеэс 1-ээр нэмэгджээ. 2020-2021 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх насны байгууллагын нэг багшид ногдох хүүхдийн 25 байгаа нь өмнөх оноос 5 (16.0%)-аар буурчээ.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

### АЖИЛЛАГЧДЫН ТОО, бүсээр 2020

Ажиллагч гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ.

Зураг. 6. АЖИЛЛАГЧДЫН ТОО, бүсээр 2020



Нийт ажиллагчид 28119 байгаагийн 13777 буюу (49.0 %) нь эмэгтэйчүүд, 14342 (51.0%) нь эрэгтэйчүүд байна. Мөн ажиллагчдын тоог төвийн бүстэй харьцуулахад харь 15.1 хувийг эзэлж байгаа бол улсын хэмжээний ажиллагчдын 2.4 хувийг тус тус эзэлж байна.

## ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН /ажилгүйдлийн түвшин/

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

1. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно.

2. Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм. а. хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг; б. ажил хийхэд бэлэн гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг; в. ажил хайж байгаа гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.


3. Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм. Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд: а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн; б. Ажил хайгаагүй ч ажил



хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.

Улсын хэмжээнд явагдаж байгаа “Ажиллах хүч” түүвэр судалгааны үр дүнгээр тооцсон аймгийн хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин /ажилгүйдлийн түвшин/ 4.1 байгаа нь өмнөх оноос 0.2 пунктээр өсж, улсын дунджаас 2.9 пунктээр бага байна.

Зураг.7. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, аймаг, бүс, улс 2020



Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин /ажилгүйдлийн түвшин/ улсын хэмжээнд 7.0 хувь байгаа бөгөөд, Баян-Өлгий, Дорнод, Дархан-Уул аймаг улсын дунджаас 5.6-13.6 пунктээр дээгүүр, харин Завхан, Төв, Дундговь аймаг 3.9-5.4 пунктээр доогуур байна.

Аймгийн хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшинг /ажилгүйдлийн түвшин/ хүйсээр авч үзвэл, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин 2.9 хувь, байгаа нь өмнөх оноос 2.3 пунктээр, улсын дунджаас эмэгтэйчүүдийн 3.8 пунктээр бага байна.

## ГЭМТХЭРЭГ

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2020 онд 318 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 132 хүн гэмтэж, 10 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оноос 232(42.2%)-оор , гэмтсэн хүний тоо 90 (40.5%) -ээр, нас барсан хүний тоо 14 (58.3%)-өөр тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх онтой харьцуулбал хүний өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 75(34.9%)-аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 73(43.2%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 15(55.6%)-аар, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 21(65.6%)-ээр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 18(40.9%)-аар, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 5 (50.0%)-аар, авлигын гэмт хэрэг 6(85.7%)-аар, хүний халдашгүй, чөлөөт байх эрхийн эсрэг гэмт хэрэг 3(60.0%)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2(11.1%)-оор тус тус буурчээ.

Зураг. 8. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, төрлөөр



## ДҮГНЭЛТ

Манай аймгийн нийт 20 494 өрхийн 43.8 хувь нь гэрт, 55.7 хувь нь байшинд, 0.5 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Өмнөх 2010 онтой харьцуулахад байшинд амьдардаг өрх 1.1 пунктээр нэмэгдэв. Энэ нь сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд нэмэгдсэнээр орон сууцанд амьдардаг өрхийн тоо нэмэгдсэн байна. Энэ нь хүний амьдралын анхдагч хэрэгцээ, эрүүл энх, тав тухтай, аюулгүй амьдрах үндсэн орчин бол орон сууц юм.

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, жижиг оврын цахилгаан үүсгүүр өргөн ашиглах болсон.

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн хангамж, хүрэлцээг тодорхойлж, цаашид холбогдох бодлого, хөтөлбөр, боловсруулах суурь, мэдээлэл бүрдүүлснээрээ ач холбогдолтой юм.

Нийт өрхийн 78.2 хувь нь төвлөрсөн системд холбогдсон өрх, 20.3 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй өрх, 0.9 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүртэй өрх, 0.2 хувь дизель станцтай өрх, харин нийт өрхийн 0.4 хувь нь цахилгааны ямар нэг эх үүсвэргүй байна.

Өрхийг халаалтын эх үүсвэрээр авч үзвэл нийт өрхийн 13 264 (64.7%) нь ердийн галлагаатай өрх, 6 573 (32.1%) хувь нь төвлөрсөн системд холбогдсон өрх, 517 (2.5 %) нь нам даралтын зуухтай өрх, 140 (0.7%) нь цахилгаан халаагуурын эх үүсвэртэй өрхүүд байна.

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.

Аймгийн өрхийн бохир ус зайлуултыг авч үзвэл нийт өрхийн 7844 (38.3%) нь цооногт, 6272 (30.6%) нь ил задгай, 6252 (30.5%) нь төвлөрсөн системд холбогдсон, 126 (0.6%) нь бие даасан системтэй өрхүүд байна.

Өрхийн хатуу хог хаягдлыг нэгдсэн бодлогоор ангилан ялгаж, тогтсон газар зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам сүлжээгээр зайлуулж, цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдолд ихээхэн нөлөөтэй. Ялангуяа, хүн хүн ам ихээр төвлөрсөн томоохон, суурин газруудад хатуу хог, хаягдлыг дахин боловсруулах, иргэдэд хогоо ялгаж зайлуулах ухамсрыг төлөвшүүлэх зэрэг олон асуудалд энэхүү үзүүлэлтүүд суурь мэдээл болно.

Аймгийн нийт өрхийн 11256(54.9%) нь үйлчилгээний байгууллагаар, 3543(17.3%) нь тогтсон цэг байхгүй, 4778(23.3%) нь зөвшөөрөгдсөн цэгт, 917(4.5%) нь бусад/шатаадаг, булдаг/ газарт хог хаягдлыг зайлуулдаг өрхүүд байна.

Энэхүү судалгааны өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал нь суурь мэдээлэл болох юм.

**Танилцуулгыг хянан тохиосон:**

Х.Өлзийсүрэн                      Статистикийн хэлтсийн дарга

**Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:**

Б.Энхцэцэг                      Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ:**

WWW.1212.mn

- Ажиллах хүчний судалгааны тайлан 2020
- ХАӨМСан-хүн ам өрхийн мэдээллийн сан
- Дорноговь аймгийн 2020 оны жилийн эцсийн эмхэтгэл

Цахим хаяг: [www.dornogovi.nso.mn](http://www.dornogovi.nso.mn)

[www.1212.mn](http://www.1212.mn)

E-mail: [Dornogovi@nso.mn](mailto:Dornogovi@nso.mn)

Утас: 70522749

